



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/291

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Авто замын сангийн хөрөнгө оруулалт, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Сумын төвийн хатуу хучилттай авто зам барих ажлын үргэлжлэл (Орхон сум)-ийг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Энх алтаргана” ХХК-тай 822,715,122 (найман зуун хорин хоёр сая долоон зуун арван таван мянга нэг зуун хорин хоёр) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

3.Тус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Орхон сумын Засаг дарга (Н.Амартүвшин)-д үүрэг болгосугай.

4.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Энх алтаргана” ХХК-ийн захирал (А.Энхжаргал)-д даалгасугай.

5.Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

6.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу аймгийн Авто замын сангийн хөрөнгө оруулалтаас 300,000,000 (гурван зуун сая) төгрөгөөр, Орхон сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас 536,075,882 (таван зуун гучин зургаан сая далан таван мянга найман зуун наян хоёр) төгрөгөөр тус тус санхүүжүүлэхийг аймгийн Төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Сайнзаяа), Орхон сумын Засаг дарга (Н.Амартүвшин) нарт зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324010388

Аймгийн Засаг даргын 2024.1. оны
001 дүгээр сарын 29-ний өдрийн А/2.51. дугаар
захирамжийн хавсралт



д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадлашгүй ажил	14,175,325	Ү.Бямбасүрэн
2	Зөвлөх үйлчилгээний зардал	31,061,838	Ү.Бямбасүрэн
3	Захиалагчийн хяналтын зардал	0	Ү.Бямбасүрэн
4	Норм, нормативын сан	2,835,065	Ү.Бямбасүрэн
5	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Батцогт
6	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь	Д.Батцогт Ү.Бямбасүрэн
7	Ажил гүйцэтгэх хугацаа	60 хоног	Ү.Бямбасүрэн